

Соёлын бүтээлч үйлдвэрлэл

“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрийн арга хэмжээний хүрээнд 14 сумын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. “Эгшиглэнт говь” соёлын өдрийн үзэсгэлэн худалдаанд 14 сумын 420 төрлийн гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэлгэн үзүүлж 150 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 3500 гаруй хүн үзэж сонирхсон. Монгол Улс даяар өрнөж буй “Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд аймгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 10 иргэн, 3 аж ахуй нэгжийн бүтээлийг аймгийн төв талбайд дэлгэн үзүүлж 500 гаруй иргэн оролцсон. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд уламжлалт гар аргаар урласан монгол модон ширээ, бурхны гүнгэрваа бүтээлээр, модон сийлбэр, оньсон тоглоом, үхэр гэр тэрэг, таван хошуу малын модон сийлбэрүүдээ дэлгэж, лимбэ хөгжим, эсгий, тэмээний ноосон урлал, морин хуур хөгжим урлалын төрөлд Д. Уламбаярын бүтээсэн морин хууруудыг дэлгэж гар урлалын гэрийн үзэсгэлэнг дэглэж олон нийтийн хүртээл болгосон. Мөн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асарт Загасгал цай, Чулуун гоёл, Эко саван, монгол малгай урлал зэрэг орон нутгийн онцлох брэнд бүтээгдэхүүнүүдийг борлуулан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 480 хүнд үйлчилгээ үзүүллээ.

